

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны даргын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/036/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2025 он

Монгол Улсын Ерөнхий аудиторын
Орлогч: Я.Самбууням
Утас: 261945 Цахим хаяг: sambuunyamya@audit.gov.mn
Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261945 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: В.Эрдэнэцогт
Утас: 261885 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn
Ахлах аудитор: М.Пагамдулам
Утас: 261628 Цахим хаяг: pagamdulamm@audit.gov.mn
Аудитор: Б.Отгонцэцэг
Утас: 261628 Цахим хаяг: otgontsetsegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН САЙД, 20 МИНУТЫН
ХОТ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА
Р.ЭРДЭНЭБҮРЭН ТАНАА

2025.04.25 № 1589
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Монгол улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангууд, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 7 дугаар сарын 24-ны өдрийн 08 дугаар тогтоолоор байгуулагдаж, Нийслэлийн Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны чиг үүргийг 20 минутын хот Үндэсний хороонд шилжүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр 20 минутын хот Үндэсний хорооны даргын чиг үүргийг хотын хэт төвлөрлийг сааруулах, нийгмийн үйлчилгээг 20 минутын дотор авах, хүнд ээлтэй шинэ орчин, нөхцөлийг бүрдүүлэх бодлогын зохицуулалт, авто замын түгжрэлийг бууруулах, төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж,

аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 3 төсөл, арга хэмжээнд нийт 116,229.2 сая төгрөгийн төсөв баталснаас гүйцэтгэлээр 87,931.2 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвөөс олгосон байна.

Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах чиглэлээр Буянт-Ухаа спорт цогцолбороос Торгоны замын хөшөө хүртэл 12.3 км тусгай замын автобус төслийн судалгаа, төлөвлөлтийг хийж гүйцэтгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Замын хөдөлгөөний соёлд уриалсан “Түгжрэл бидний тархинд, шийдэл бидний хандлагад” нэртэй 2 контент бүтээж, сошиал орчинд түгээж, 240,000 хандалтад хүрсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАГДЖАВ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	50,000,000.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	50,000,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	-	50,000,000.0
4	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	50,000,000.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	50,000,000.0
41300	Өглөг	-	50,000,000.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	-	50,000,000.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	87,931,220.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	87,931,220.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-	87,931,220.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	87,931,220.0
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал	-	87,931,220.0

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
11	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	-
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	-

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	-	137,931,220.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	50,000,000.0
120	Нийтлэг татварын бус орлого	-	50,000,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	87,931,220.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	137,931,220.0

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	87,931,220.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	87,931,220.0
2200	Дотоод эх үүсвэрээр	-	87,931,220.0
220001	Барилга байгууламж	-	60,000,000.0
222001	Тоног төхөөрөмж	-	27,931,220.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(87,931,220.0)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	50,000,000.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	50,000,000.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	116,229,186,800.00	87,931,220,000.00	28,297,966,800.00	75.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	116,229,186,800.00	87,931,220,000.00	28,297,966,800.00	75.7
220001	Барилга байгууламж	70,500,000,000.00	60,000,000,000.00	10,500,000,000.00	85.1
222001	Тоног төхөөрөмж	45,729,186,800.00	27,931,220,000.00	17,797,966,800.00	61.1
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	116,229,186,800.00	87,931,220,000.00	28,297,966,800.00	75.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	116,229,186,800.00	87,931,220,000.00	28,297,966,800.00	75.7
310001	Улсын төсвөөс санхүүжих	116,229,186,800.00	87,931,220,000.00	28,297,966,800.00	75.7

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 50,000.0 сая төгрөгийн бүртгэл, тайлагналтай холбоотой алдааг аудитын явцад залруулж, үйл ажиллагааны үр дүн, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлтэй холбоотой 1 зөрчилд албан шаардлага өгсөн.

Аудитаар нийт илрүүлсэн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

1. Тус хорооны 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүнг хангаж ажиллаагүй, хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээг гүйцэтгээгүй, үйл ажиллагааны үр дүн, санхүүжих эх үүсвэрийг уялдуулж төлөвлөөгүй, хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал:

- Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны чиг үүргийг 20 минутын хот үндэсний хороонд шилжүүлсэн бөгөөд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр авто замын түгжрэлд нөлөөлж байгаа хүчин зүйлийг тогтоож эрх зүйн орчинг сайжруулах, хүүхдэд замын хөдөлгөөнд оролцох мэдлэг дадлыг суулгах, торгууль төлүүлэх байдлыг хялбарчилж, шугам замын хяналтыг сайжруулах гэсэн 3 хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөөд хэрэгжүүлээгүй;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх бүтээн байгуулалтын төслийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах ажил 10,000.0 сая төгрөг, нэгдсэн менежментийн зөвлөх үйлчилгээ авах 50,000.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээний зөвхөн сонгон шалгаруулалт зарласан, он дамжин хэрэгжүүлэхээр санхүүжилтийг барьцаа дансанд төвлөрүүлж, өглөгөөр бүртгэсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 31 дүгээр зүйлийн 31.1.2-д “хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх”, 41 дүгээр зүйлийн 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах”, Сангийн сайдын 2023 оны 12 дугар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалын хавсралтаар баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.3-д “Тухайн жилийн төсөвт он дамжин хэрэгжихээр тусгагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд тусгаж, тайлбарт он дамжин хэрэгжиж байгаа талаар дурдана” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын биелэлтийг хангуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Аудитаар нийт 50,000,0 сая төгрөгийн 1 алдаа илрүүлж, аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
					Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн байдлын тайланд бусад эргэлтийн хөрөнгө, тайлан үеийн үр дүнг 50,000.0 сая төгрөгөөр илүү тайлагнасан.	1	50,000.0	1	50,000.0	1	50,000.0				
Дүн	1	50,000.0	1	50,000.0	1	50,000.0				

4.2 Аудитаар үйл ажиллагааны үр дүн, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлтэй холбоотой 1 зөрчилд албан шаардлага өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус хорооны даргын 2024 онд хэрэгжүүлэх төсөлсөн 3 хөтөлбөр арга хэмжээ хэрэгжээгүй, хөрөнгө оруулалтаар шинээр нэмж төлөвлөсөн 2 арга хэмжээ хийгдээгүй, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтыг уялдуулж төлөвлөөгүй, үр дүн байхгүй.	1	-	1	-		
Дүн	1	-	1	-		